

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Дугаар

Чингис хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь заалт, 26 дугаар зүйл Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг “Баялаг Хурах” ХХК -ийн ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Хэнтий аймгийн зохицуулах зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Хэрлэн сум “Баялаг Хурах” ХХК-ийн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Баялаг Хурах” ХХК-ийн захирал /Д.Баярхүү/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Халаалтын нэгжийн үнийг тогтоох тухай” 2021 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Зохицуулах зөвлөлийн дарга /Л.Батсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Л.БАТСАЙХАН

ОРОН ТООНЫ ГИШҮҮН

Д.ЭРХЭМБАЯР

ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮН

Т.ЖАНЧИВ

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМ “БАЯЛАГ ХУРАХ” ХХК-ИЙН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ**

1. Хэнтий аймгийн Хэрлэн сум “Баялаг Хурах” ХХК-ийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөв болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	1,900	
2	Төсөв болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээний ус халаасан дулаан	Төг/м ³	4,000	
3	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0”-ын ерөөний халаалт хамаарна)	Төг/м ²	1,000	
4	Ахуйн хэрэгцээний ус халаасан дулаан	Төг/м ³	4,000	
5	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000
		41-81 м ² талбайтай айл өрх	Төг/сар	5,000
		81 м ² –с дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000